



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 0/01

Арвайхээр сум

Цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2 дахь заалт, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 4, 5, 6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Журам батлах тухай" 9 дүгээр тогтоолын хавсралтын 2.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 3, 10 дугаар хавсралт, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг шинэчилсэн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар шинэчлэн тогтоосон цалин, урамшууллыг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (А.Гантуяа)-д зөвшөөрсүгэй.



Ц.БОЛДБААТАР

522601002